

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГДЭЭР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 50 (2314) 1974 оны 7 дугаар сарын 4 ПҮРЭВ

ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Аймгийн Намын XVI бага хурал зохион байгуулалт дээр сурталын өндөр хэмжээнд явагдаж өнгөрсөн 3 жилийн ажлын байдал, олсон амжилт, дутагдалд дүгнэлт хийж цаашдын зорилтыг тодорхойлон заална. Тус бага хурлаас 1974 онд мал өсгөх улсын төлөвлөгөөг төрлөөр нь биелүүлэн дүнгээр нь 1975 оны хэмжээнд хүргэх өнгөрсөн гурван жилийн дундаасаа зүй бүсхорогдлыг 40-оос доошгүй хувиар багасган, 1975 онд олонхи суурьт МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас тавьсан зорилтыг хангах, таван жилд улсад тушаах ургацнаас дутуу байгааг нохон биелүүлэх, таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн туршилагыг нийтийн хүртээл бэлтгэх замаар нийт ажлаараа тэргүүний аймгийн хэмжээнд хүрэх зорилтыг дэвшүүлсэн юм.

Энэхүү дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Намын анхан шатны бүх байгууллага, аж ахуйн захиргаанд V таван жилийн эхний 3 жил хагасын төлөвлөгөөг бүх үзүүлэлтийг бригад, ферм, суурь, цех албан үйлдвэрийн газар бүрээр гарган судалж, Намын гишүүд, нийт ажилчинд, хөдөлмөрийн хамт олны хурлаар хэлэлцүүлж дутууг нохон биелүүлэх тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Урьдчилсан судалгаанаас үзэхэд тус аймагт 5 жилийн төлөвлөгөөний гол 101 үзүүлэлтээс 40 гаруй үйлдвэрлэлдээгүй байна. Илангуяа 1973 онд байх ёстой малаас үхэр 19 мянга, адуу 23,0 мянгаар дутуу байгаа юм.

Энэ нь 1973 онд сүүний 50 гаруй, үнээний 30 гаруй хувь нь сувайрч төл авч чадаагүйтэй холбоотой байна. V таван жилийн төлөвлөгөөг зорилтоос эхний 3 жил 6 сард дутуу биелэгдэж, тасарч болзошгүй байгаа үзүүлэлтүүд илангуяа бод мал, сүү ноосны төлөвлөгөөнд нарийн судалгаа хийж, 1974 оны сүүлийн хагас, 1975 онд бүрэн хангах нь чухал байна. Үүний тулд зуны улирлын сайханд тайвшралгүй малын хорогдлыг багасгах малыг отроор таргалуулах, малаж ахуйн овлийн ба хадлан тэжээл бэлтгэх ажлыг сайн зохион байгуулж өргөн айлалт, бэлчээрийг хуваарьтай ашиглах, мал аж ахуйн хэсгийн зохион байгуулалт зэрэг тэргүүний арга туршилагыг бүтээлчээр эхлэх нь чухал.

Илангуяа бод малыг жилийн 4 улиралд байнгын хариуцаа маллагатай болгож, үнээ гүүний хээлтүүлэг, төлөлтөнд онцлон анхаарч бод малыг төрлөөр нь өсгөхөд манай ХАА-н байгууллага нийт малчдын гол зорилт оршино. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлдөөс цогцлийн тос, цагаан идээ үйлдвэрлэх ажлыг сайжруулах арга хэмжээний тухай санхүү гаргасан тогтоол болон энэ оны сүүлийн төлөвлөгөөг заавал биелүүлэх, энэ талаар урьдлаах нарийн болзол гаргаж саальчинд малчдын идэвхийг өрнүүлэх хэрэгтэй.

Онцйн нодлоох шалтгаангүйгээр хугацаа алдаж зохион байгуулах, мал нэг бүрээс авах ашигт шимийг бүрэн ашиглах эрмэлзлэл сулаас ноос бэлтгэх төлөвлөгөөг 3 жил дараалан тасалсан дутагдалд дүгнэлт хийж, ноосны төлөвлөгөөг төрөл бүр дээр нь биелүүлэх цөөн хонгийн эрчимтэй ажил зохиож дүгнэвэл зохино.

Тариаланчид сүүлийн хоёр жилд төлөвлөгөөн дээрээ үр тариа 16,2 мянган, төмс 1000 гаруй, хүнсний ногоо 4000 гаруй тонн нэмж үлдсэн тушаах шаардлагатай байна. Бага хурал үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар үзэж муу, нэр төрлийн төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, хуаадаа, НААУГ, тээвэр холбоо, ардын боловсрол, соёл эрүүлийг хамгаалах байгууллагуудын үйлчилгээний соёл шүүрхэй байдал дутагдалтай байгааг аригтахын чухлыг зансан юм. Дээрх газрууд үйлдвэрлэлийн ажиллагааг механикжуулах, цагийн алдагдалтай тэмцэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулан нэр төрлийг олшруулах, социалист өмчийг хамгааж арвижуулах талаар эрэмбэ дараатай арга хэмжээ авах нь зүйтэй.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД МАНАЙ АЙМАГТ

Чехословакийн Эмэгтэйчүүдийн Төв Холбооны орлогч дарга Малецка Ярамила, Славек мужийн Намын хорооны эмэгтэйчүүдийн ажил эрхэлсэн нарийн бичгийн дарга Агнеса Чатнова нар манай аймагт саяхан зочлов. Төлөөлөгчид орон нутгийг судлах болон уулын музей үзэж, Сэргэлэн сумын Авдархангай нэгдлийн малчин Гончигийн суурьт очиж малчин эмэгтэйчүүдийн ажил амьдралтай танилцав.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

Аймгийн улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийн тухай Статистикийн товчооны мэдээлэл

1974-7-2

Гурав. Их барилга

Манай аймгийн нийт хөдөлмөрчид МАХН-ын XVI их хурал, бүгд хурлуудын түүхэн шийдвэрийг хэрэгжүүлэх, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтах уриан дор бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлж ажилласны үр дүнд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг зорилтуудыг амжилттай биелүүлж байна.

Нэг. Ходоо аж ахуй

Аймгийн хэмжээгээр 6 дугаар сарын 30-ны байдлаар төлөвлөх зохих хээлтэгч малын 92,7 хувь буюу 545,2 мянга нь төлөгж 551,9 мянган төл гарсны 97,6 хувь буюу 538,8 мянга нь бойжиж байна.

Энэ онд аймгийн дүнгээр 121,6 мянган га-д үр суулгаж жилийн төлөвлөгөөг 101,8 хувиар биелүүллээ.

тариалсан талбай (мянган га)	төлөвлөгөөний биелэлт (хувиар)
Үр тариа	107,2
Төмс	1,8
Хүнсний ногоо	0,9
Тэжээлийн ургамал	11,7
Төлөвлөгөөний биелэлт (хувиар)	103,0
	88,5
	100,2
	93,4

Аймгийн хэмжээгээр 20,2 мянган малын багтаамжтай 61 хашаа барьж жилийн төлөвлөгөөний 51,3 хувийг, орон нутгийн хүчээр уурхайн худаг 15-ыг гаргаж жилийн төлөвлөгөөний 53,6 хувийг биелүүллээ.

Хоёр. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн газруудын нийт бүтээгдэхүүн гаргах төлөвлөгөө 114,3 хувиар биелэгдэж төлөвлөгөөнөөс 867,3 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлээд байна.

Үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнийг төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл (хувиар)

Төлөвлөгөөний биелэлт	өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал
Хүнсний комбинат	128,7
Хөвлөх үйлдвэр	114,3
НААУ-ний газар	112,1
Ой аж ахуй модны үйлдвэр	110,1
Архустын ТАА	81,4
Эрдэсзангын ТАА	61,4
Баянцогтын тэжээлийн үйлдвэр	115,7
Угтаалын тэжээлийн	43,0
Төлөвлөгөөний биелэлт	100,5
	94,7
	110,7
	73,7
	2,0 да
	133,1
	2,8 да
	106,0

НААУ-ний газар гутал, төмөрзлэл үйлдвэрлэх төлөвлөгөөг 6,4-31,2 хувиар, ойно аж ахуйн модны үйлдвэр зүсмэл материал үйлдвэрлэх төлөвлөгөөг 13,8 хувиар тасалдууллаа.

САА, ХАА-н нэгдлүүд аж ахуйн аргаар 1386,9 мянган төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж жилийн төлөвлөгөөний 31,7 хувийг, Нэгдэл дундын үйлдвэр 792,2 мянган төгрөгийн барилга угсралтын ажил хийж жилийн төлөвлөгөөний 56,8 хувийг биелүүллээ.

Барилга угсралтын ажлын төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл:

төлөвлөгөөний биелэлт	өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал
Барилга угсралтын контор	124,2
Замын анги	2,7 да
Төлөвлөгөөний биелэлт	129,8
	188,9

Усны аж ахуй удирдах газар өрөмдмөл худаг 13-ыг, уурхайн худаг 40-ийг гаргаж хагас жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүллээ.

Доргов. Тээвэр, холбоо

Авто тээврийн 13 дугаар бааз 21,6 мянган тонн ачаа тээж 3003,3 мянган тонн км-ийн ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс ачаа эргэлт 302,9 мянган тонн км-ээр нэмэгдэв. Тээвэр, холбооны байгууллагуудын төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл; (хувиар)

Төлөвлөгөөний биелэлт	өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал
Тээсэн ачаа	101,4
Ачаа эргэлт	109,2
Зорчигчдын тоо	4,9 да
Зорчигчид эргэлт	123,8
ТУ газрын орлого	123,8
Харилцаа холбооны орлого	108,7
Төлөвлөгөөний биелэлт	81,3
	111,2
	156,8
	91,2
	109,2
	111,2

Тав. Худалдаа бэлтгэл

Жижиглэн худалдаалах бараа гүйлгээний төлөвлөгөө 100,1 хувь биелэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 102,1 хувь буюу 841,2 мянган төгрөгөөр их байна.

Жижиглэн худалдаалах бараа гүйлгээний төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг байгууллагуудаар үзүүлбэл: хувиар

төлөвлөгөөний биелэлт	өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал
Бараа гүйлгээ	100,0
Номын гүйлгээ	80,0
Хөвлөлийн гүйлгээ	101,9
Эмийн гүйлгээ	105,1
Төлөвлөгөөний биелэлт	102,2
	90,1
	102,7
	102,1

(Төгсгөл нь II нүүрт)

Аймгийн улс, ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийн тухай Статистикийн товчооны мэдээлэл

Төгсгөл. (Түрүүч нь I пүүрт)

Мах, ноос бэлтгэлийн төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл: (хувиар)

	төлөвлөгөөний биелэлт	өнгөрсөн оны мөн үе-тэй харьцуулбал
Мах бэлтгэл	101,4	78,5
Тэмээний ноос	69,7	95,5
Уртын ноос	16,4	39,1
Ямааны ноос	66,4	106,2
Ямааны ноолуур	100,0	109,6
Бодын хөөвөр	87,6	70,5
Бодын хялгас	104,3	67,6

Б лтгэлийн 43-н төрлийн зүйлээс 23 нэр төрлийн төлөвлөгөө 100 ба дээш хувиар биелэгдээд байна.

Зургаа. Соёл, ардын боловсрол, эрүүлийг хамгаалах

Соёлын байгууллагуудын орлогын төлөвлөгөө 139,3 хувиар биелэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1,2 хувиар багасчээ.

Соёлын байгууллагуудын орлогын төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг үзүүлбэл: (хувиар)

	төлөвлөгөөний биелэлт	өнгөрсөн оны мөн үе-тэй харьцуулбал
Соёлын ордон	111,7	91,3
Кино театр	137,2	113,3
Нүүдлийн кино	140,3	89,1
Фото зургийн салбар	114,3	87,8
Дүрслэх салбар	136,3	109,1
Музейн орлого	134,9	6,1 да

1973—1974 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 7, 8, 10 дугаар ангийг 1,3 мянган хүүхэд төгсч төлөвлөгөө 99,8 хувиар биелэгдлээ.

Эрүүлийг хамгаалах байгууллагуудын төлөвлөгөөний биелэлт, өсөлтийг

үзүүлбэл: (хувиар)

	төлөвлөгөөний биелэлт	өнгөрсөн оны мөн үе-тэй харьцуулбал
Амбулаторийн үзлэг	112,6	100,2
Ор хоногийн ашиглалт	104,8	103,5
Урьдчилан сэргийлэх тарилга	100,6	86,0
Яслийн хүүхэд өдөр	96,9	107,4

Сумдын зарим ажлын төлөвлөгөөний биелэлтийг үзүүлбэл (хувиар)

	төл бойжилт	тариалалт	уринш	хашаа барилт	Хээлтүүлэг		бараа гүйлгээ	мах бэлтгэл	тэмээний ноос	ямааны ноос	ямааны ноолуур	уртын ноос	бодын хөөвөр	бодын хялгас	сүү тушаалт
					гүү	үнээ									
Алтанбулаг	98,0	73,1	0	42,8	40,5	31,6	88,3	100,7	65,4	35,8	100,6	32,0	100,0	128,3	38,7
Батсүмбэр	96,9	100,0	38,5	66,6	43,8	34,1	100,9	43,0	100,0	107,5	105,9	4,3	100,0	122,9	46,6
Баян	99,3	100,0	50,0	0	55,5	19,3	91,2	104,9	62,9	73,9	102,9	24,5	78,6	97,2	7,6
Баян-өнжүүл	99,1	110,5	16,7	100,0	52,4	42,7	86,8	132,1	69,0	63,6	101,8	27,1	87,5	89,6	18,3
Баяндэлгэр	91,6	141,3	0	0	64,6	49,2	98,8	89,6	34,0	10,0	100,9	0,3	102,6	107,1	26,4
Баянжаргалан	99,1	112,0	33,3	42,8	45,0	26,2	111,7	100,0	72,4	91,1	100,1	29,9	87,2	100,3	9,3
Баянзүрх	99,0	100,0	60,0	66,6	43,0	34,4	144,5	99,6	100,0	100,0	100,0	31,5	100,0	111,3	18,8
Баянцагаан	99,9	100,0	40,0	100,0	48,4	22,5	100,1	79,8	65,7	85,2	103,1	22,3	81,1	100,1	16,7
Баянцогт	99,2	100,1	89,2	66,6	18,7	17,3	100,0	92,0	67,9	67,1	107,4	12,6	94,8	118,3	18,6
Борнуур	97,3	101,5	67,9	100,0	45,7	26,8	106,1	65,9	=	115,2	124,5	26,0	87,1	107,8	39,5
Бүрэн	96,8	99,6	40,0	0	62,3	57,5	65,5	100,9	75,2	78,9	99,2	5,6	83,6	98,0	20,7
Дэлгэрхаан	98,4	100,0	=	60,0	56,4	27,0	92,5	100,0	71,2	62,4	102,5	20,0	76,2	103,6	18,7
Жаргалант	95,1	102,1	83,2	50,0	24,7	19,5	101,4	58,9	3,8 да	120,3	2,5 да	1,0	93,7	107,7	=
Заамар	90,6	87,3	49,9	0	64,3	31,0	98,2	101,0	74,3	92,3	92,6	58,8	100,0	100,0	52,6
Лүн	98,8	117,2	10,7	33,3	49,0	54,6	88,6	100,5	76,5	72,5	91,9	21,3	100,2	119,2	13,3
Мөнгөнморьт	98,8	100,0	100,0	100,0	22,2	24,7	107,1	116,2	96,1	41,0	91,8	0	97,5	100,1	45,5
Өндөрширээт	98,6	100,9	51,8	71,4	30,9	10,6	113,0	106,6	55,9	61,2	100,5	17,2	85,1	100,0	8,1
Сэргэлэн	99,1	100,2	43,3	60,0	62,9	40,9	104,5	102,8	66,9	61,6	100,6	17,4	65,0	112,3	28,3
Угтаал	99,5	101,4	100,0	0	25,3	22,1	105,9	65,4	77,1	35,3	81,0	0	86,6	117,5	=
Эрдэнэ	92,2	108,3	94,5	50,0	45,3	34,3	113,8	104,9	56,7	16,6	76,8	1,5	57,2	85,2	24,0
Эрдэнэсант	98,8	100,1	97,7	81,8	34,5	26,1	101,5	116,4	70,3	49,9	97,7	0	82,0	100,1	22,1
Баянчандмань	98,3	=	=	33,3	46,6	21,4	89,2	100,3	115,5	133,3	100,0	36,4	108,6	122,0	=

Статистикийн товчоо

ЗӨВЛӨЛТИЙН ШИНЭ ИХ ТУСЛАМЖ

Монгол-Зөвлөлтийн ард түмний хоорондын найрамдал гандан бууршгүй бат бэх, үнэтэй зүйл болохыг Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн мөнх найрамдлын 50 гаруй жилийн түүх яруу тод нотлов.

Социализмын ууган оронтой тогтоосон интернационал харилцаа бүх талын хамтын ажиллагаа, Зөвлөлт андын сэтгэл хамраггүй тусламж дэмжлэг нь тус орны олон зуун жилийн хоцрогдлыг арилгах, социалист эдийн засаг, соёлыг бүтээн байгуулж хөгжүүлэх, хөдөлмөрдийн аж байдлыг дээшлүүлэх, нийгмийн социалист харилцаа тогтооход түүхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд БНМАУ-ыг капиталист хөгжлийн шатныг алгасан социализмд амжилттай шилжин хөгжихөд шийдвэрлэхүйц тус дөхөм үзүүлсэн билээ.

ЗХУ-ын техник эдийн засгийн тусламж, Зөвлөлт

анд нөхдийн гар бие оролцоогүйгээр бий болсон үйлдвэр аж ахуй, соёл, газарзүйн нэг ч салбар манай оронд байхгүй гэж хэлж болно.

Зөвхөн манай аймагт Зөвлөлтийн ард түмний хүч хөрөнгөөр иж бүрэн тохиожсон ХАА-н нэгдэл, ТАА, сүүний фермүүд ажиллаж Зөвлөлт нөхөд маань баялаг туршлагаа монгол нөхөддөө өвлөн эзэмшүүлж байна.

ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжаар сүүлийн 12 жилд улс ардын аж ахуйн чухал ач холбогдол бүхий 150 гаруй үйлдвэр, барилга байгууламжийг барьж ашиглалтанд оруулсан бөгөөд ардын хувьсгалын 50 жилийн ойгоор 5 сургууль, 2 больницын иж бүрэн барилга, Алтанбулагийн хувьсгалын музей, Улаанбаатар дахь хүүхдийн сүү тэжээлийн газрыг тус оронд бэлэглэсэн юм.

Хагас зуу гаруй жилийн

турш ариун тунгалаг бат оршиж мөнхжсөн Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааны хэлбэрэлтгүй бэхжилт нь пролетарийн интернационализмын зарчимд тулгуурласан найрамдлын аугаа их хүчин чадлыг дэлхий нийтэд илтгэн харуулсаар байна.

Үүний нэг тод илрэл нь ЗХУКН, Зөвлөлт засгийн газраас БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан манай оронд үзүүлэхээр болсон шинэ их тусламж юм.

БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан ЗХУ-аас эх орны маань улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэхэд нэмэлт хувь нэмэр болжог дотуур байр, багш нарын орон сууц бүхий тус бүр 964 хүүхэд суралцах иж бүрэн 2 сургуулийн барилга, жилдээ 70 мянган хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууц ба-

рих хүчин чадалтай байшин үйлдвэрлэх комбинатыг барьж өгнө.

Мөн өргөн хэрэгцээний барааны хангалтыг улам сайжруулах зорилгоор ЗХУ-аас манай оронд 15 сая рублийн үнэ бүхий өргөн хэрэгцээний олон төрлийн бараа таваарыг 1974 онд багтаан буцалтгүй тусламж болгон нийлүүлэх гэж байна.

Энэ тусламжаар улс орныхоо алс нутагт радио нэвтрүүлгийн хэрэгслийг хөгжүүлэхэд зориулан 60 сая рублийн буюу 500-гаад сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлэх шийдвэр гаргалаа.

Энэ тусламжаар улс орныхоо алс нутагт радио нэвтрүүлэх хэд хэдэн систем Улаанбаатар, Алтай, Баян-өлгийн хооронд 2900 километр урт радио релейн шугамыг барьж байгуулах, алсын зайд нэвтрүүлэг дамжуулах нилээд хэдэн агаарын шугамыг тоноглох юм.

Түүнчлэн манай засгийн газрын хүсэлтийг хү-

лээн авч ЗХУ-аас тус орны эдийн засгийг хөгжүүлэх ард түмний аж байдлыг дээшлүүлэхэд туслах зорилгоор ЗХУ-д нийлүүлж байгаа мал, махны гадаадын үнийг дахин нилээд их хэмжээгээр нэмэгдүүлэх болсон нь тус орны эдийн засгийн хөгжилтөд чухал ач холбогдолтой зүйл боллоо.

Монголын ард түмний сайн сайхны төлөө анхаарал халамж нэвт шингэсэн ЗХУ-ын ах дүүгийн шинэ их тусламж нь манай орны хөдөлмөрдийг үнэхээр баярдуулан өөрийн оронд социализмын материал техникийн бааз байгуулахын төлөө тэмцэлдээ их амжилт гаргах урам зоригийг нь бадрааж байна. Монгол-Зөвлөлтийн ард түмний ган бат найрамдал бол Монголын ард түмний хувь заяа, гэрэлт ирээдүй, аз жаргал, сайн сайхан хөгжилт бүхий гол чухал эх сурвалж байсан, байх ч болно.

3. БАЯРБАТ

Хэвлэгдсэний нь 55 жилийн ойд

Зөвлөлт засаг тогтсон анхны жилүүдэд социалист нийгмийн суурь дөнгөж тавигдаж, коммунизмын үрээс анхны зарим соёо цухуйж байсан үед Ленин тэр шинэ сэргэг зүйлсийг соргоогоор тусган авч тэдгээрийн ач холбогдлыг зааж, амьдралын шинэ үзэгдлийг гүнзгий шинжилж, социализм, коммунизмын тухай, түүний хөгжлийн зүй тогтоолын тухай чухал үндэслэлүүд дэвшүүлсэн бүтээлүүд туурвисны нэг нь «Их санаачлага» зохиол юм.

Ажлыг хувьсгалч ёсоор хийх «Төв Хорооны урианы, хариуд 1919 оны 5 дугаар сарын 10-нд Москва, Казанийн төмөр замын 205 ажилчид ажил тарсны дараа төмөр замын дөлд сайн дураараа 5 цаг ажиллаж 4 галт тэрэг, 16 вагон засварлаж, 9300 пүүр тариаг ачиж буулгасны хөлс нь 5000 рубль болсон бөгөөд энэ ажлыг үнэ хөлсгүй хийсэн байна.

Харин хөдөлмөрийн эрчим ердийн үеэс 270 хувиар илүү байжээ.

Үүний дараа Александрин төмөр зам, Вязьмын чиглэлийн замууд дээр, Тверь, Саратов хотуудад коммунист субботник хийж, олон газарт дэмжжээ. Энэ үе нь интервенцийн довтолгоон, Колчак, Деникинний эсрэг давшилтаа улаан цэргийн дайчид их амжилт олж цаашид дайсныг бүрмөсөн ялахад эв нэгдэл сэтгэл санааны дэмжлэг, ар талын бат бөх байдал чухлаар нөлөөлөх үе байв.

Ийм үед «Коммунизмын жинхэнэ эхлэл» гэж Лениний тодорхойлсон коммунист анхны субботник болсон юм.

Социализм, коммунизм гэж юу болох, шинэ нийг-

мийг байгуулах зам ямар болохыг практик дээр харуулсан субботникийн ач холбогдлыг Владимир Ильич өндрөөр үнэлж «Москва—Казанийн төмөр замын ажилчдын коммунист субботник бол дэлхийн бүх ард түмнийг капиталын дардал, дайны аюулаас аврагч шинэ социалист нийгэм урган соёолж байгаагийн нэг илрэл мөн» гэжээ.

(В. И. Ленин, зох.—4 дэх хэвлэл 29 дүгээр боть, 418 дахь талд)

В. И. Ленин, хөдөлмөрийн капиталист зохион байгуулалт нь өлсгөлөн, ажилгүйдлээс айх явдалд тулгуурладаг бол социализмаас эхлэж байгаа хөдөлмөрийн коммунист зохион байгуулалт нь хөрөнгөтөн, помещикийн дарлалыг түлхэн унагаа-

нийгмийн шинэ байгуулал, ялангуяа коммунизмын ялалтад үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн чухалыг товлон тавьсан юм.

Ленин «Нийгмийн шинэ байгуулал ялахад хамгийн чухал, хамгийн гол зүйл бол эцсийн дүнд хөдөлмөрийн бүтээмж мөн.

Хамжлагат ёсны үед үзэгддэггүй хөдөлмөрийн бүтээмжийг капитализм бий болгосон юм.

Социализм хөдөлмөрийн шинэ бөгөөд капитализмынхаас хавьгүй их бүтээмжийг бий болгож капитализмыг бүрэн ялж чадна, ялах ч болно гэж бичжээ. (В.И. Ленин, зох.—4 дэх хэвлэл, 29-р боть, 421 дэх тал)

Коммунизмын тухай Марксын сургаалд чухал хувь нэмэр болсон Ильичийн энэ үндэслэлээс

цуу хуулиар бататган заасан ёсоор эзэмшиж байгаа байдал, нийгмээс хөдөлмөрийг зохион байгуулахад гүйцэтгэх роль, үүнээс уламжлан нийгмийн баялагаас хүртэх арга, мөнхүү баялгаас оногдсон оногдлын хэмжээгээрээ ялгаатай бүлэг хүмүүсийг анги гэнэ, гэж тодорхойлоод (зохиолуудын 4 дэх удаагийн хэвлэл, 29 боть—415 дахь тал) ангиуд бүрэн устаагүй цагт ангийн тэмцэл байх нь зайлшгүй учир пролетари нар засгийн эрхийг аваад ангийн тэмцэлийг зогсоохгүй харин ангиудыг бүрэн устгах хүртэл үргэлжлүүлнэ.

Тэгэхдээ өөр байдлын дотор, өөр аргаар үргэлжлүүлэх нь мэдээж.

Ангиудыг бүрэн устгаж гэвэл зөвхөн мөлжигчдийг түлхэн унагаж тэдний өмчийг устгаад зог-

Социализмын дээд шат коммунизмын үед бол нийгмийн тусын тулд үнэ хөдсгүй, хөдсний тооцоогүй ажиллах болно.

Энэ нь хөдөлмөр эрүүл бие махбодийн зайлшгүй хэрэгцээ болж хувирна гэсэн үг юм.

Коммунист субботник нь тийм хөдөлмөрийн анхны эх үүсвэр болсон юм гэж заажээ.

Лениний энэ зохиол багахан нэг субботник нь коммунист их хөдөлмөрийн үр нахиа юм гэдгийг цаг үед нь ажиглан мэдэж, шинэ залуу Зөвлөлт засгийн эзэд болсон ажилчид коммунистуудаас ирээдүйг ойртуулах оргилуун эрмэлзлэлээр хийж байгаа их санаачлага гэж өндөрөөр үнэлсэн үнэлэлт, социализм коммунизм байгуулагчдын хөдөлмөрт хандах, хөдөлмөрөө үнэлэх, санаачлан ажиллахын тухайд өгсөн асар их ач холбогдолтой мөнхийн сургаал юм.

Бас ч бага зүйлээс их үйлст хүрэхийн жишээ, бага зүйлээс их санаа авахын дууриалал гэж хэлж болох юм.

Ч. ЖАНЧИВДОРЖ

В. И. ЛЕНИНИЙ «ИХ САНААЧЛАГА» ЗОХИОЛЫН ТУХАЙ

сан хөдөлмөрчдийн өөрсдийн нь чөлөөг, ухамсарт сахилга батад тулгуурладаг. Коммунизм гарцаагүй бүрэн ялахын баталгаа хүч чадлын уг сурвалж үүнд байгаа юм гэж заажээ.

Ухамсарт хөдөлмөрийн илрэл болсон субботник нь хөрөнгөтнийг унагаахаас ч илүү хүнд, ноцтой, үндсэн шийдвэрлэгч эргэлтийн эхлэлт тавигдсаныг харуулсны дээр капитализмаас ажилчин тариачинд өвлөж үлдээсэн дадал заншил хөшүүн, салал залгалт байдал, жижиг хөрөнгөтний хар амиа боддог чанар зэргийг устгах ялалт болж байгаад агуу их ач холбогдол оршиж байна гэж Ленин үзжээ.

Ленин, энэ зохиолдоо

«хэн нь хэнийгээ, гэдэг асуудлыг зөвхөн улс орны дотоодод шийдвэрлээд зогсохгүй, капитализмыг эдийн засгийн талаар давахын төлөө хоёр системийн эдийн засгийн уралдааны тухай санаа гарч ирж байна.

Владимир Ильич үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэхийн чухал болох тухай асуудалтай уялдуулан пролетарийн диктатурын мөн чанар, пролетарийн диктатурын үеийн ангийн тэмцэл, ангиудыг устгах асуудлыг тайлбарлаж, ангийн тухай сонгомол тодорхойлолт өгсөн байна.

В. И. Ленин «Түүхийн ёсоор тогтсон нийгмийн үйлдвэрлэлийн тодорхой нэг системийн дотор эзлэх байр суурь, үйлдвэрлэлийн хэрэгслийг «гол-

сохгүй, үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх аливаа хувийн өмч, хот хөдөөгийн хоорондын ялгавар биеийн ба оюуны хөдөлмөрийн хүмүүсийн хоорондын ялгаврыг устгах хэрэгтэй.

Урт удаан хугацаанд биелэгдэх энэ ажлыг биелүүлэхэд үйлдвэрлэх хүчнийг асар их хөгжүүлж, жижиг үйлдвэрлэлийн олон тооны үлдэгдлийн эсэргүүцэл, эдгээр үлдэгдэлтэй холбогдсон дадал заншил, хөшүүн хойрго байдлын асар их хүчийг даван туулах хэрэгтэй.

Энэ үүргийг засгийн эрхийг байлдан авч өөрийн диктатурыг тогтоосон пролетари нар гүйцэтгэж чадна.

Пролетарийн диктатур бол мөлжигчдөд дан ганц хүч хэрэглэх биш

АЖИЛЧ БУУРЛУУДЫН НЭГ

Донид 1959 онд нэгдэлд элсээд адуучин болжээ.

Саруул—амьдрал нэгдлийн зөвлөлийн шийдвэрээр сүүлийн жилүүдэд зааз мал авч арчлан тэжээв. Тэрээр юуны урьд өвчин ба уналга эдэлгээ, арчилгаа маллагааны буруугаас тогтсон гажиг согоогийг мал нэг бүр дээр үзэж тогтоон түүнийг эдгээхээр ардын уламжлалт эмнэлгийн арга барилыг өргөн хэрэглэжээ.

Жишээлбэл: Наран, усан, тосон жилбэн тогтсон малыг ханах, хатгах, төөнөх, хөлөргөх, сойх эмийн ургамлын үндэс шарилж, халгай, цайны хандалсан уусмал, шөл, сүү, уураг зэргийг тодорхой хэмжээтэй өгдөг байна.

Хөгшин үхэрт загасны тос, глюкоз зэргийг өдөрт 2 удаа 150 грамм аар өгч тэнхрүүлдэг аж.

Хөгшин малд тэжээлийг нунтаглаж дэвтээн

исгэж тохирсон хэмжээгээр тогтмол өгөх нь амт чанар шингэл сайтай болдог ба ямар ч хөгшин мал түргэн тэнхэрч таргалдаг гэж ярьж байна.

Донид малдаа хавар эрт агь, яргуй идүүлж, зун намарт соргог бэлчээр дагаж богино хугацаанд товшин нүүдэллэдэг юм. Жилийн аль ч улиралд ус, хужрыг нарийн тохируулахыг эрхэмлэдэг ба өвлийн бэлтгэлээ хавраас эхлэн аажим хугацаанд хийж чанартай хангадаг болжээ.

Донид 1972 онд нэгдлийн зааз 223 үхэр харнуцан маллаж төлийн нь хоногдолгүй бойжуулж 306 болгон хүч тарга сайтайгаар нэгдэлдээ тушааж, үхрийн хөөвөр хялгасны даалгаврыг биелүүлж өнгөрсөн онд зааз малын тарга хүчний аварга гэдэг хүндэт цол хүртжээ.

Н. ШАГДАРДАГВА



Алтанбулаг сум-нэгдлийн Жаргалант бригадын хэмжээгээр 100 эхээс авах төлбөр 91.5 хувиар бойжуулав.

Зураг дээр: Жаргалант бригадын хоньчин (баруун гараас) А. Найдан, О. Пүрэвдорж, Б. Шар, Ж. Чойдорж, С. Дорж, Р. Янцандорж, Т. Очир, О. Батаа, Х. Раднаа, Ч. Түвшин, С. Чойжав, С. Сүрээ нар. Тэд төлбөр 510—572 хонь ямаагаас 510—693 төл хүлээн авч бойжуулан социалист уралдаанд хошуучилсан юм.

Д. ТОВУУ-гийн авсан гэрэл зураг

НЭГЭН АНГИЙН ХАН

Дэлгэрхаан сумын ХБ ангийн дарга, БНМАУ-ын худалдааны тэргүүний ажилтан Ш. Даштай уулзаж ярилцвал:

—Манай хамт олон түүхий эд бэлтгэлийн 31 нэр төрлийн зүйлээс 27 нэр төрлийг 100—125 хувь

биелүүлээд байна.


Ямааны ноолуурын 80 хувийг 1 дүгээр зэрэгт бэлтгэж, мах бэлтгэлийн төлөвлөгөөг богино хугацаанд цөөн тооны тарган малаар давуулав.

Бараа гүйлгээний төлөвлөгөө 101 хувь биелж

2 худалдагч, 4 агент бараа гүйлгээний төлөвлөгөөг биелүүлээд байна.

Бид ажилчдын уралдааныг «Хонхоос-Восток», хөлгөөр байр эзлүүлэн дүгнэдэг. Одоогийн байдлаар Н. Цэнд агент Т. Гаваа нь «восток» хөлгөөр аялж явна гэв.

Я. ЦЭВЭГ-ОЧИР



СОЦИАЛИСТ ХУДАЛДААНЫ ЖУРАМ ЗӨРЧИХ НЬ

Социалист худалдаа нь үйлдвэрийг хэрэгцээтэй холбож, нийгмийн баялгийг нийт гишүүдэд хөдөлмөрийн нь хирээр болон байдлаар нь хуваарилж байгаа төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Манай улсын эрүүгийн хуулинд социалист худалдааны тухай төрөөс тогтоосон журмыг зөрчсөн, нийгэмд аюултай үйлдлүүдэд хариуцлага хүлээлгэхээр (эрүүгийн хуулийн 128, 129, 130, 131 дүгээр зүйлүүд) заажээ. 1. Дамын худалдаа хийх Энэ гэмт хэрэг нь үйлдвэрийн бүтээгдэхүүнийг худалдааны шугамаар хуваарилах хуваарилалт ба иргэдийн материаллаг сонирхлын эсрэг чиглэсэн объекттай байдаг. Дамын худалдаа хийх явдал нь социалист худалдааны төлөвлөгөөт үйл

ажиллагааны эсрэг чиглэгдээд зогсохгүй, панзчин этгээд худалдан авсан бараа таваар үнэт зүйлээ өндөр үнээр худалдан бусдын хөдөлмөрийн үр хуримтлалыг мөлжих замаар хөдөлмөрийн биш орлогоор ашиг завшаан олдог давхар объектод чиглэгддэгээрээ нийгэмд аюултай гэмт хэргийн тоонд орно.

Дамын худалдаа хийх гэмт хэргийн халдлагын зүйл нь үнэт эд таваар байхаас гадна хүний хөдөлмөрөөр бүтээгдээгүй боловч хүмүүсийн хэрэгцээнд шаардлагатай эд зүйлүүд, байгалийн баялаг байж болно.

Дамын худалдаа хийх гэмт хэргийн объектив тал нь бараа таваар үнэт зүйлийг худалдан авах буюу дамлан худалдаалах хоёр хэлбэртэй байна.

Барааг бусдад дамлан худалдаалах зорилгоор бусдаас худалдан авсан бол дамлан худалдаа хийх гэмт хэргийн төгс бүрэлдэхүүнтэй гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Дамын худалдаа хийх гэмт хэргийн объектив талын нөгөө нэг хэлбэр нь бараа таваар үнэт зүйлийг дамлан худалдаалах явдал мөн. Харин ямар нэг бараа таваарыг худалдсан үйлдэл бүр дамлан худалдаа хийх гэмт хэрэг болохгүй, зөвхөн ашиг хонжоо болохоор худалдан авсан бараа, таваар, үнэт зүйлээ дамлан худалдаалах явдлаар тооцогдоно.

Зарим панзчин этгээдүүд дамлан худалдаа хийх зорилгоор худалдан авсан зүйлийнхээ зүсийг хувирган худалдаалах нь олонтой тохиолддог.

Зүс хувиргасан зүйлээ худалдаж байгаа үнэ нь түүнд шингэсэн хөдөлмөрийн хөлснөөс давж хөдөлмөрийн биш орлого оруулахад хүргэсэн бол дамлан худалдаа хийсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх учиртай.

Энэ мэт хэргийн субъектив тал нь ашиг хонжоо хайсан, ховдог шунахай зорилготой шууд санаатай үйлдлээр хийгдэнэ. Дамын худалдаа хийсэн этгээдийн энэ зорилго нь уг таваарыг худалдан авах үед буюу түүнээс өмнө үүссэн байдаг.

Иймээс ашиг хонжоо олохоор нэгэнт худалдан авсан зүйл нь дамлан худалдаалах үед ашиг олоогүй нь тогтоогдсон ч энэ гэмт хэргийн шинжийг үгүйсгэхгүй.

Хуульд дамлан худалдааг байнга буюу их хэмжээгээр үйлдвэл хүндрүүлэн үзэх шалтгаан болгон зааж нутаг зааж суулгах буюу 3—8 жилийн хорих ял оногдуулахаар тогтоосон байна.

Дамын худалдаа хийсэн гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулахад шүүхээс анхаарах нэг гол асуудал бол дамлан худалдаалахаар бэлтгэсэн зүйл буюу худалдаасан зүйлүүдийг хураан авч улсын санд нийлүүлэх явдал мөн.

(Үргэлжлэл бий)

ТОВЧХОН

Саяхан Эрүүлийг хамгаалах газрын эмч ажилчдын цуглаанаар ахмадын дайчин уламжлалыг тэмдэглэв. Бүх ажилчдын цуглааныг ЭХГ-ын намын үүрийн нарийн бичгийн дарга Ж.Доржготов нээж «Ахмадын дайчин уламжлалаас суралцъя» гэсэн лекцийг аймгийн ХЗЭ-ийн хорооны ажилтан Д.Дэмбэрэл уншиж, шинээр МХЗЭ-ийн гишүүнд элсэн мэс заслалын сувилагч Цэцэг, сувилагч Бүрэнжаргал нарын олон гишүүдэд МХЗЭ-ийн гал улаан бат илэрхийлэхийг БНМАУ-ын гавьяат хуульч аймгийн прокурор О.Лхамсүрэн гардуулж сургамжийн үг хэллээ. Мөн ЭХГ-ын дэргэдэх ХЗЭ-ийн үүрийн дарга Ц.Саруул үг хэллээ.

Г. ТҮМЭННАСТ

Баяндэлгэр сумын сум дундын больницын хан хагас жилийн амбулаторийн үзлэгийг 118,3 орхоногийг 110,2 урьдчилан сэргийлэх үзлэгийг 135 хувиар тус тус биелүүлэв.

1974 оны 5 дугаар сарын 18-ны Бямба гариг. Заамар нутгийн тэнгэрт бүртгэх ч үүлгүй цэлмэг, шившээ салхи үс үс сэвэлзэнэ.

Оройн жаргах нарны шинжир туяанд нэгдлийн төв цайран ярайж хэний ч гэсэн сэтгэлийг татах үзэсгэлэн төгөлдөр ажээ. Цайдам нуурын хойгуур Салхит хэмээх нурууны хормойгоор тасамдан гарсан урт цагаан зам нэгдлийн зүүнээс очно. Тэр замаар ГАЗ—652 маркийн шар өнгийн автобус тоос татуудан дахина. Автобус машин замын өлөн тоосонд дарагдаж бөр шаргал өнгөтэй болсон нь урт замыг туулсан нь илт.

Заамар нэгдлийн «Зочид буудал» гэсэн хааг бүхий орчин үеийн хэв хийцтэй жижиг шар байшингийн үүдэнд алгуурхан зогсов. Машинаас эрээн өнгийн дугуй тооригон малгайтай алаг хувцастай эрэгтэй эмэгтэй арав гаруй хүмүүс буусан нь баруун Алтайн хязгаарын Баян-Өлгий аймгийн театрын жүжигчид ажээ.

Ядарсан биений алжаал тайлж түр амрахаар гар цүнх хөгжим зэргээ барьж буудлын хаалгыг аяархан татаж ороход 17—18 орчим насны бүсгүй угтлаа.

Тэр бүсгүйтэй мэнд усаа мэндэлцэхэд тэр бүсгүй зовонгуй царай гарган дуугарч ядан байв.

Буудлын дотор тал мөбиль хэрэглэл, хивс зэргээр тохиожсон нь нүдэнд дулаан.

Үйлчлэгч бүсгүйн ца-

райд нэгэн гуниглал байгааг жүжигчин хүний гархай нүдээр ажигласан жүжигчдийн ахлагч Сереквай тэр эмэгтэйн уйтгарыг тайлах зорилгоор доомбор хөгжимдөө хэдэн мөч «Жороо моринны явдал» хэмээх казак ардын дууны аягууг хөгжимдөж дараа нь бүсгүйн зүсийг асууж танилчилж буудлын эрхлэгч Ичинхорлоо гэж хариулав.

Дуучин охин Камела, Ичинхорлоод хандан нүүр гар угаах халуун ус байна уу гэхэд байхгүй гэж хариулав. Гуанз хаа байна гэхэд байхгүй гэж хариулав.

ДУУЛЖ ИРСЭН КАМЕЛА УЙЛЖ БУЦСАН НЬ

(ШОГ НАЙРУУЛАЛ)

—Цай уудаг газар бий юу гэхэд. Мөн байхгүй гэв. Байхгүй гэсэн гурван хариултанд гайхаш нь тасарсан Камела охин, энэ төвд гуанз хаа байх вэ гэхэд. —Манай энд гуанз гэж ерөөсөө байхгүй шүү. ХБА-ийн харьяа нэг гуанз мортой хүнд бол хоёр өртөө газар, машинтай хүнд бол хоёр цагийн газар, Туулын хөвөөн дээр байдаг юм гэлээ.

Камела яларч ирсэн болохоор жаахан халуун цай яаж олж уух билээ гэж Ичинхорлоог царайчлан асуухад:

—Чамайг орой тоглоод

ирэхэд чинь найз чинь гэрээсээ нэг данх цай авчирч өгье гэж өгүүлэв.

Яларч ирсэн жүжигчид мэл гайхаж цэл хөхөрсөн бололтой ахлагч Сереквай руу ширтэв.

Сереквай: —Танай энэ буудалд ажлаар ирсэн хүмүүний хаанаа аж хооллодог юм бэ гэж лавлан асуухад Ичинхорлоо: —Буудалд ирсэн хүн хоосон хонож байгаад, сүүлдээ дасдаг бололтой юмаа. Жишээ нь: Манай

аймгаас энэ буудалд 3 хүн байрлаж байгаа, анхандаа хоол, цай хаана ууж идэх вэ гэж сураг-

байтал өндөр, нам хоёр залуу орж ирэв.

Нэг нь аймгийн ХАА удирдах газрын эдийн засагч Д.Лхагваа, нөгөө нь аймгийн соёлын хэлтсийн дарга Ц.Далхсүрэн гэдэг хүн байв.

Энэ хоёр мөн л 2—3 хоног энэ буудалд аяганы амсар зуулгүй айл хэсэг цай хоол царайчилж яваа хүмүүс байв.

Ц.Далхсүрэн өгүүлсэн нь, Аймгийн төвөөс наашаа төлөөлөгчөөр гарахад Заамар нэгдэлд очсон төлөөлөгч ходоод нь муудаж ирдэг юм даа гэж найз нэгэн залуугийн хэлсэн үг үнэн байжээ гэж санаа алдав.

Оройн 20 цаг болж жүжигчид амаа чийглэлгүй цагийн хуваарьт захирагдаж нэгдлийн клуб очиж тоглов. Дуучин охин Камела доомбор хөгжимд казак ардын дууг гоцлон тоглож бүжиглэхэд үзэгчдийн алга ташилт аадар бороо шиг шаагиж Камелаг 3—4 удаа дахиулав. Камела ам нь цангаж нилээд ядарсан бололтой, тоглолт тараад нэгдлийн буудал руу явахдаа цай, хоол, ус байгаа болов уу, үгүй болов уу гэж бодлогошрон алхав. Жүжигчдийн буудалд ороход өвөрлөж орсон сайхан сэтгэгдэл таларх өнгөрч цөм л Камеланы нэгэн ижил буудалд цай хоол байгаа болов уу гэж санаашран хоорондоо үг ч дуугарахгүй шахам явсаар буудалд ирэхэд үйлчлэгч

Ичинхорлоо ч байхгүй, цай хоол ч байхгүй урьдынхаа л хэвээр байв.

Хэдэн мөчийн дараа Ичинхорлоо гэрээсээ нэг данх хүйтэн ус барьж ирэхэд жүжигчид зөвхөн нүүр, гараа угааж унтаж амрах болов.

Дуучин охин Камела цангасандаа болоод хүйтэн уснаас хоёр гурав балгахад жүжигчдийнх ахлагч Сереквай—хүйтэн ус уух дуучин хүнд хоригтой зүйл гэхэд Камеланын зүүн нүднээс өөрийн эрхгүй доголлон нулимас дулав. Ингэж дуулж ирсэн охин уйлж буцав.

Энэ баримтаас үүдэж Заамар нэгдлийн үйлчилгээ аж ахуй эрхэлсэн орлогч дарга Сандуйжав болон нэгдлийн хариуцлагатай нөхөд нэгдлийнхээ зочид буудлын талаар эрхбиш анхаармаар санагдлаа.

Нэгдлийн зочид буудал 5 хүний орон тоотой 15 ортой, зорчин явагчдыг хооллож ундлах цайны газартай мөртлөө ганцхан тогооч өвчтэй нэрийдлээр ажлаар ирсэн хүмүүсийг унд хоол өгөхгүй гомдоож буцаадгийн учир юунд байна вэ?

Ер нь нэгдлийн төвд хөдөлмөрчдийн хэрэгцээнд зориулсан ногоо, мах, сүүний мухлаг ажиллахгүй, халуун зун ч гэсэн хөдөлмөрчид бараг л хар цай ууж байхад нэгдлийн саалийн үнээ тугал эхлээр явж байгаа нь бас хачирхалтай.

Ш. БЯМБАА

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ